**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 02 өдөр Дугаар А/375 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1 аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 27 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

5. Монгол Улсын Засгийн газраас 2022 оныг хоршооны хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан, хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажилтай уялдуулж хоршооны үйл ажиллагааг сурталчлах, идэвхжүүлэх, гишүүдийг сургаж чадавхжуулах, хоршоог үнэлэх, ажлыг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 1,523,000 (Нэг сая таван зуун хорин гурван мянган) төгрөгийг зарцуулсугай.

6. Дээрх үйл ажиллагааны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

7. Дээрх зардлын 1,523,000 (Нэг сая таван зуун хорин гурван мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

8. Арга хэмжээг удирдамжийн дагуу зохион байгуулж, үр дүнг засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

9. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш. ДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны ~~10~~ 11
дугаар сарын .02.. ний өдрийн ..А/376..
дугаар захирамжийн хавсралт

| № | Хугацаа | Шаардагдах шатахууны зардал | Сумдын нэр |
|---|---|---|---|
| 1. | 2022-10-17<br>2022-10-21 | 250,000 | Алаг-Эрдэнэ, Хатгал, Ханх, Чандмань-өндөр, Цагаан-үүр, Эрдэнэбулган, |
| 2. | 2022-10-24<br>2022-10-28 | 250,000 | Түнэл, Тосонцэнгэл, Их-уул, Тариалан, Рашаант |
| 3. | 2022-11-01<br>2022-11-06 | 250,000 | Төмөрбулаг, Шинэ-идэр, Галт, Жаргалант |
| 4. | 2022-11-07<br>2022-11-11 | 150,000 | Мөрөн, Бүрэнтогтох, Цагаан-уул, Цэцэрлэг |
| 5. | 2022-11-14<br>2022-11-18 | 623000 | Арбулаг, Баянзүрх, Улаан-уул, Ренчинлхүмбэ, Цагаан-нуур |
| | Дүн | 1,523.000 | |

_____oOo_________